

“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” II шат “Төслийн мэдээ” сонин

Гарчиг

- СТАРТ2 төслийн хугацаа дуусна
- Өнөөг хүртэлх тэгш хамран сургах боловсролын үйл ажиллагааны үр дүнгээс
- СӨБ-ын багш нарт зориулсан “Тэгш хамран сургах боловсролын хянах хуудас”
- Төслөөс бэлтгэн гаргасан Тэгш хамран сургах боловсролын холбогдолтой эцсийн бүтээгдэхүүнүүд
- Түгээн дэлгэрүүлэх зорилтот сургуулиудын сайн жишээ, туршлагаас

2024 оны
5 дугаар сар,
Дугаар 5

 Тус сонины дугаар 5-тай танилцаж буй танд баярлалаа. Энэхүү дугаар нь тус төслийн сүүлийн дугаар болно. Өнөөг хүртэлх дугаарууд танд хэрэгтэй мэдээлэл өгч чадсан бол бид туйлын баяртай байна. Цаашдаа ч таны ажил үйлсэд тус нэмэр үзүүлэх болтугай.

СТАРТ2 төслийн хугацаа дуусна

2020 оны 9 дүгээр сард хэрэгжиж эхэлсэн тус төслийн дуусах хугацаа ойртож байна.

Энэхүү 4 жилийн (Өмнөх шатыг оролцуулбал нийт 8 жил!) турш тус төсөлтэй хамтран ажиллаж ирсэн бүх хүнд гүн талархал илэрхийлье.

Төслийн хугацаа дууссан ч, Монгол Улсад тэгш хамран сургах боловсрол биеллээ олж, бүх хүүхдэд өөрсдийн эрэлт хэрэгцээндээ нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг авна гэдэгт бат итгэж байна.

Өнөөг хүртэлх тэгш хамран сургах боловсролын үйл ажиллагааны үр дүнгээс

■ Үйл ажиллагааны цар хүрээ тэлэлт

Улаанбаатар хотод

Тус бүр 25 цэцэрлэг, сургуульд тэгш хамран сургах боловсролын төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлж, мониторинг болон зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулав.

Тэгш хамран сургах боловсролын суурь мэдлэг болон цэцэрлэг, сургуулийн дэмжлэгийн багийн үйл ажиллагаа зэрэг сэдвээр нийт 28 удаа сургалт зохион байгуулав.

Бүсийн төв аймагт

Төв, Дорнод, Өмнөговь, Хөвсгөл, Ховд аймгийг бүсийн төв аймгаар сонгон тус бүрд 2-3 цэцэрлэг, 2 сургууль, нийт 11 цэцэрлэг, 10 сургууль сонгож ажиллав.

2022-2023 онд аймаг бүрд нийт 3 удаа мониторинг хийж, тэгш хамран сургах боловсролын үйл ажиллагаанд зөвлөн туслав.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, салбар комиссын гишүүдийг чадавхжуулах зэргээр нийт 91 удаагийн сургалт зохион байгуулав.

Үндэсний хэмжээнд

Бусад 16 аймгийн цэцэрлэг, сургуульд мониторинг, зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулж, Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал зохион байгуулахад чиглэсэн зөвлөгөө өгч, БШУГ-тай уулзалт зохион байгуулав.

Танхим, цахим хэлбэрээр нийт 26 удаа сургалт зохион байгуулав.

■ Төслийн холбогдох мэргэжилтний сэтгэгдэл

Би 2003 оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байна. Өнгөрсөн жил тэгш хамран сургах боловсролын мэргэжилтнээр томилогдсон. Анх тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхэд мэдэхгүй зүйл олон гарч байсан. Дараа нь БШУЯ, БЕГ, СТАРТ2 төслийн сургалтад хамрагдаж, нийслэл болон Төв аймгийн мониторингт оролцсоноор ойлголтоо гүнзгийрүүлж, цаашид хэрхэн ажиллах тодорхой арга зүй, чиглэлтэй болсон. БШУГ-ынхаа бага боловсрол хариуцсан мэргэжилтэн болон СӨБ хариуцсан мэргэжилтний хамтаар Дорноговь аймгийн тэгш хамран сургах боловсролыг түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Аймгийнхаа цэцэрлэг, сургуулиудад мониторинг хийхдээ, бүх боловсролын байгууллагуудад дэмжлэгийн баг ажиллаж, тусгай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд татан оролцуулахаар тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлж буйг олж хардаг. Дэмжлэг шаардлагатай хүүхдэд тохирсон арга зүйгээр ажиллах, суралцах орчин бүрдүүлэх, боловсон хүчнийг чадавхжуулах зэрэг сайжруулах асуудлууд байгаа хэдий ч Дорноговь аймгийн тэгш хамран сургах боловсролыг түгээн дэлгэрүүлэхийн төлөө цаашид ч хичээж ажиллана.

Дорноговь
аймгийн
ТХСБ-ын
мэргэжилтэн
Н.Мөнхцэцэг



Төслийн багтай хамт мониторинг хийх үед

“СӨБ-ын багш нарт зориулсан тэгш хамран сургах боловсролын хянах хуудас”

Цэцэрлэг бүр өөрсдийн тэгш хамран сургах боловсролын хэрэгжилтийг тогтмол хянах “СӨБ-ын багш нарт зориулсан тэгш хамран сургах боловсролын хянах хуудас” болон ашиглах аргачлал, анхаарах зүйлсийг танилцуулъя.

Дараалал

1. Хичээлийн шинэ жил эхлэхэд, эсвэл зорилтот хүүхэд шилжиж ирэх үед бүлгийн багш/дэмжлэгийн баг бөглөнө.
2. Дэмжлэгийн багаар үнэлгээ хийн, сайжруулах шаардлагатай агуулгын хүрээнд цэцэрлэгийн зүгээс хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлно.
3. БШУГ/БХ-ийн СӨБ хариуцсан мэргэжилтэн цэцэрлэгүүдэд ажиллахдаа, энэхүү хянах хуудастай нь танилцан шаардлагатай арга хэмжээг авна. (→ 1-3 циклээр дахин хийнэ)

Асуулт	Биелэлт				
	Сайн хийж чадаж байгаа	Бага зэрэг хийдэг	Сайн хийж чадахгүй байгаа	Хамааралгүй асуулт	Санал, зөвлөмж
Асуулт нэмэх шаардлагатай бол дэмжлэгийн баг хэлэлцэн асуулт нэмж болно.					
Багш					
Бүлгийн сургалт, үйл ажиллагааг хүүхэд бүрийн сонирхол, чадвар, чадамжид тулгуурлан зохион байгуулдаг уу?					Зорилтот хүүхэд сурдаггүй тохиолдолд “Сайн хийж чадахгүй байгаа”-г биш,
Хэл ярианы бэрхшээлтэй хүүхдэд зурган карт ашиглах, үйл хөдлөл, илэрхийлүүлэх зэрэг янз бүрээр өөрийгөө ойлгуулах тохируулгыг хийдэг үү?					
Өдрийн дэглэмийн үйл ажиллагааны дараалал мөн гар угаах дараалал зэргийн ашиглан ойлгомжтой байдлаар дүрслэн, хүүхдийн харааны түвшинд байгаа байгаа юу?		☒	☐	☐	Багшийн хичээл, сургалтын орчныг бүх хүүхдэд зориулсан/хүүхдийн өсөлт хөгжилд чиглэсэн тохируулга хийсэн эсэх асуултууд багтана.
Сонсголын бэрхшээлтэй хүүхэд хамрагддаг бол дохионы хэлээр эсвэл удаанаар ярих, ярьсан зүйлийг зургаар хавсаргах зэрэг шаардлагатай тусламж хийдэг үү?					
Оюуны хөгжлийн хоцрогдолтой/бэрхшээлтэй хүүхэд хамрагддаг бол удаанаар, тодорхой, дэлгэрэнгүй, давтан, үйл хөдлөлөөр тайлбарлаж өгдөг үү?	☐	☒	☐		
Анхдагч хэл нь Монгол хэл биш бол нэмэлтээр суралцах боломжийг нь олгодог уу?					Одоо “Хийхгүй” байгаа ч, дараагийн улиралд хийх, эсвэл сайжруулах санал байвал тэмдэглэнэ.
Бусад багш нарт бүлгийн сургалт, үйл ажиллагаа болон дэмжлэг шаардлагатай хүүхдийг танилцуулж, санал солилцон, хамтран ажиллах боломжийг бүрдүүлдэг үү?	☒	☒	☐		
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлснээр хүүхдэд тулгарч буй асуудал, зэрэг өөрчлөлтийг бусад багш, арга зүйч, эрхлэгчид хуваалцаж, цэцэрлэгийн түвшинд хамтран ажиллах тогтолцоо бүрдсэн үү?	☒	☒	☐	☐	
Тэгш хамран сургах боловсролын үндсэн ойлголт, заах арга зүйн талаар багш нарт зориулсан сургалтад хамрагдах, ном товхимлыг уншин суралцах боломж байдаг уу?	☐	☒	☒	☐	
Цэцэрлэгийн орчин					
Цэцэрлэгийн байр (анги, коридор) болон гадна талбайн хувьд тэргэнцэртэй эс таягтай хүүхдүүд ашиглах боломжтой олон талын тохируулга хийсэн үү? (заах хангалттай юу, шатаас өөр арга бий юу?)					Энд, бие эрхтэн, эсвэл харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тохируулгыг хийсэн эсэхтэй холбоотой асуултууд багтсан. Мөн, аутизмтай хүүхдэд зориулсан “Ганцаараа амрах орон зай”-г бүрдүүлсэн эсэх зэрэг асуулт багтсан.
Аутизмын хүрээний эмгэгтэй төстэй шинж тэмдэг илэрч буй хүүхэд, хэт мэдрэлтэй түгшил ихтэй хүүхдүүдийг тайвшруулахын тулд анги дотор мод, ургамал тарьж эсвэл ганцаараа амрах боломжтой орчин бүрдүүлсэн үү?					
Харааны бэрхшээлтэй хүүхэд ердийн номын санг ашиглах боломжгүй тул тэдэнд зориулсан дижитал номын сан (хэрэглэгдэхүүн), мэдээлэл харилцааны технологийг ашигладаг уу?	☒	☒	☐	☐	
Цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээ					
Бүлгийн багш дэмжлэгийн багаар дамжуулан бусад багш нарт мэдээллээ хуваалцаж, хөгжлийн бэрхшээлтэй, хэл, соёлын ялгаатай, шилжин ирсэн хүүхдийг бүлэгтээ дасан зохицоход нь цэцэрлэгийн түвшинд тохируулга хийдэг үү?					Цэцэрлэгийн түвшинд дэмжлэг шаардлагатай хүүхдэдтэй хэрхэн ажиллахтай холбоотой асуултууд багтсан. Цэцэрлэгийн удирдлага бөглөвөл тохиромжтой.
Ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнд хичээл практикийн зардлын 5-аас багагүй хувийг зарцуулж чадаж байна уу?	☐	☐	☐	☐	
Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах					
Бүх эцэг эх, асран хамгаалагчтай хүүхдийн өсөлт хөгжил, сонирхол, хэрэгцээ, анзаарсан зүйлсийн талаар ярилцах боломж байдаг уу?					Багш асран хамгаалагчтай тогтмол харилцаж, гэр бүлийн орчин дахь хүүхдийн байдлыг тандах, асран хамгаалагчийн ойлголтын талаар ярилцах боломж бүрдүүлдэг эсэх асуултууд багтана.
Эцэг эх, асран хамгаалагчтай хүүхэд гэртээ хэрхэн цагаа өнгөрөөдөг талаар ярилцаж, зөвлөмж авдаг уу?					

Бүх багш, ажилтнууддаа ойлголт, мэдлэг өгөх хэрэглэгдэхүүн болгож ашиглахыг зөвлөе.

Энэхүү хянах хуудсыг дэмжлэгийн багийн гишүүд төдийгүй бүх багш, ажилтнууддаа нэг удаа бөглүүлээд үзээрэй. Тэгш хамруулан сургах боловсролын тухай ойлголт өгөх, цэцэрлэгийн хэмжээнд хамтран ажиллах тогтолцоо бүрдүүлэхэд тань тустай байх болно.



Аутизмын тухай ойлголтоо сайжруулъя

Цэцэрлэг, сургууль дээр очиход “Аутизмын тухай илүү мэдмээр байна” гэсэн санал олон ирдэг. Тиймээс бид аутизм, түүний онцлогийг тайлбарлахаар бэлтгэлээ. Илүү дэлгэрэнгүй мэдмээр байвал энэ хуудас дахь хаягаар орж видео, гарын авлагатай танилцана уу.

Хүүхэд нэг бүрийн онцлог өөр

Америкийн сэтгэцийн эрүүл мэндийн нийгэмлэгийн DSM-5 оношилгооны шалгуур бий болсноос хойш “Аутизмын хүрээний эмгэг” гэж нэрлэгдэх болсон. Нэлээд өргөн хүрээний эмгэг юм. Аутизмтай хүмүүст тулгардаг онцлог шинж чанар, сорилт бэрхшээлүүд нь хүн бүрт харилцан адилгүй байдаг ба тодорхой нэг хэсэг зүйлд илрэх бус өргөн “хүрээ-спектр” хэмээн нэрлэсэн юм. Жишээлбэл, зарим хүмүүс хэл яриа байхгүй байхад зарим нь маш өндөр чадвартай байх, алтгаа нэг юманд хэт туйлшрах явдал хүн бүрт өөр өөр байдаг.

Шалтгаан нь мэдэгдэхгүй хэвээр

Аутизмын шалтгаан тодорхойгүй ч, эцэг эхийн хүмүүжил, хүчирхийлэл, эсвэл гэнэтийн цочролын улмаас үүсдэг гэвэл тийм биш юм. Энэ нь хүний уураг, тархинд мэдээлэл боловсруулдаг төв мэдрэлийн тогтолцооны төрөлхийн өөрчлөлттэй холбоотой гэж үздэг. Аутизм ихэнхдээ 3 нас хүрэхээс өмнө оношлогдож байгаа бөгөөд, 18 сартай хүүхдийн үзлэгээр магадлалыг илрүүлэх нь ч бий. Хэрвээ хүүхдүүдийг эргэн тойрны хүмүүс нь зөв ойлгохгүй, зохих дэмжлэг авч чадахгүй бол сэтгэлийн түгшүүртэй амьдрах, сургууль завсардах зэрэг хоёрдогч асуудлууд үүсч болно.

Онцлог: Хүмүүстэй харилцахдаа муу

Тэд хүмүүсийг төдийлөн сонирхдоггүй, бусдад хандах, харилцах өвөрмөц арга барилтай. Тэд нөгөө хүнийхээ мэдрэмж, нөхцөл байдал гэх мэтийг давхар ойлгохдоо муу,яг бодит байдал, логик дээр тулгуурлан үйлдэл хийх хандлагатай байдаг тул найз нөхөд нь муу, хувиа хичээсэн хүүхэд гэж боддог. Онцлог зан үйлийн жишээг дурдвал:

- ◆ Багадаа “баяртай” гэж хэлэхдээ алгаа өөр рүүгээ эргүүлдэг.
- ◆ Гадны хүнээс гэрэвшихгүй, эцэг эхээ дагадаггүй.
- ◆ Бусадтай ярилцаж байхдаа нөгөө хүнийхээ нүүрний хувирал, дууны өнгө, харц зэргээс нь сэтгэл хөдлөлийг нь ойлгож чадахгүй.

Онцлог: Сонирхол, үйл хөдлөл нь хязгаарлагдмал

Тэд зарим зүйл, дүрэм журам дээр маш нарийн ханддаг, эсвэл дахин давтдаг хэвшилд автсан, жишээлбэл төлөвлөгөө гэнэт өөрчлөгдөхөд сандардаг. Өөрийн сонирхол, арга зам, хурд, дарааллыг өөрчлөх чадвар муу тул уян хатан байх нь тэдний хувьд маш хэцүү, жишээ нь:

- ◆ Багадаа нэг анимэ дээрх нэг ижил үзэгдлийг дахин дахин үзэж, дээш доош үсэрч, ижил үйлдлийг дахин давтдаг
- ◆ Тэдний хоол идэх дараалал, хувийн эд зүйлсээ хаана байрлуулах дүрэм журам байдаг тул үргэлж тэр янзаар байхаас нааш тав тухгүй.
- ◆ Машин, түүх, тоо гэх мэт цээжилж болохуйц тодорхой зүйлд маш их сонирхол, тэмүүлэлтэй байдаг ч тэдгээрийн хүрээ хязгаарлагдмал байдаг.
- ◆ Заримдаа нэг зүйлд хэт их төвлөрдөг.

Онцлог: Мэдрэхүйн ялгаатай байдал

Мэдрэхүй нь хэт мэдрэмтгий, эсвэл мэдрэмжгүй байх хандлагатай. Хэт мэдрэмтгий нь түлхүү байх бөгөөд чанга дуу чимээг сонсох чадваргүйгээс чихээ дарах, зарим амтыг мэдрэх мэдрэмж, дуртай дургүй хоол хэт ялгаатай байх зэрэг шинжүүд хүн бүрт өөр өөр байдаг. Жишээ нь:

- ◆ Хүйтэн өдөр нимгэн хувцас, халуун өдөр зузаан пальто өмсөөд хэвийн явах
- ◆ Хөдөлгөөний эвсэл муу, гүйх болон үйл хөдлөл хийх нь эвгүй харагдах
- ◆ Цагаан цаас харахаар нүд анивчиж, дээр нь бичсэн үгийг уншихад бэрхтэй
- ◆ Хувцасны шошго, оёдол арьсанд хүрэх мэдрэмж авч чадахгүйгээс хувцас өмсөж чадахгүй байх г.м

Дэмжлэгийн үндэс: Тайван байх орчин бүрдүүлэх

Аутизмтай хүүхдийн онцлогийг харгалзан аль болох амьдрах орчныг тохируулах нь дэмжлэгийн үндсэн хэлбэр юм. Жишээ нь, “Бүрэн бүтэцтэй байх” арга байна. Энэ нь хэзээ, хаана, юуг, ямар аргаар, яасан үед дуусах, дууссаны дараа юу болох талаар тодорхой байлгах гэсэн үг юм. Та үүнийг өдөр тутам хичээлдээ болон ангийн орчиндоо хэрэглэж чадна. Жишээлбэл, та тухайн өдрийн цагийн хуваарийг зураг эсвэл бичвэрээр үзүүлэн хананд наавал, нүдээрээ харангаа бэлтгэлтэй байна, энэ нь хүүхдийн сэтгэлийг тайван байлгана.

Миний өглөөний дэглэм

Өглөө босо  ☐	Хувцсаа өмснө  ☐	Өглөөний цайгаа ууна  ☐
Шүдээ угаана  ☐	Тутлаа өмснө  ☐	Гадаа гарна  ☐

Жишиг хуваарь. Дуусмагц ☐-г зөвлөнө.

Хуудас 3

Төслөөс бэлтгэн гаргасан тэгш хамран сургах боловсролын холбогдолтой эцсийн бүтээгдэхүүнүүд

Тус төсөл та бүхэнд зориулан гарын авлага, видео контентуудыг боловсруулсан. Дараах QR кодыг уншуулан татаж авах боломжтой тул өргөнөөр ашиглана уу.



“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд тэгш хамруулахад чиглэсэн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл”
БШУЯ эмхэтгэн гаргасан.



“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн эмхэтгэл”
ХНХЯ эмхэтгэн гаргасан.



“Тэгш хамран сургах боловсролтой холбоотой видео хичээлүүд”

БЕГ-тай хамтран боловсруулсан бөгөөд видео хичээлүүдийг medle.mn-ээс үзэх боломжтой.



“Хүүхдийн цэцэрлэгт тэгш хамран сургах үйл ажиллагааг зохион байгуулах нь (Зөвлөмж)”
Цэцэрлэгийн удирдлага, багш нарт зориулсан тэгш



Төслийн баг янз бүрийн байгууллагуудтай хамтран туршилтын бичил төслүүдийг хэрэгжүүлж, гарын авлага, видео сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг бэлтгэсэн. Доорх QR кодыг (зарим бүтээгдэхүүн) уншуулан ашиглах боломжтой.



Төслийн I шатны эцсийн бүтээгдэхүүнүүдийг доорх QR кодыг (зарим бүтээгдэхүүн) уншуулан ашиглах боломжтой.



“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн гарын авлага”
Энэхүү гарын авлагаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бодит байдлыг судалж, тухайн хүүхдэд тохирсон дасгал, даалгавар боловсруулсан жишээг танилцуулж байна.



“1000 үгтэй дохионы хэдний карт”
Дохियोны хэл сурахад зориулсан зурган картууд бөгөөд өдөр тутмын амьдралд тохиолдох юмс үзэгдэл, үйл үг, дүрслэлийг дохионы хэл, хурууны үсгийн хамт оруулсан.



“Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж”
Унших, бичих, тооцоолон бодоход хүндрэлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж, тохирох дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зөвлөмж



“Видео хичээл”
Дауны хам шинж, аутизмын хүрээний эмгэгийг эрт илрүүлэх, ойлголтыг дээшлүүлэх, бага насны хүүхдийн хөгжлийн тухай видео хичээлүүд юм.



“Өдөр тутмын хэрэглээний 450 үгсийн зурган цомог”
Хүүхдийн ойлголтыг дэмжих зорилготой зурган таних тэмдэг, фото зураг ашигласан хичээлийн хэрэглэгдэхүүн



“Аутизмын хүрээний бэрхшээлийн тухай ойлголт”
Аутизмтай хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, багш нарын аутизмын тухай ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор бэлтгэн гаргасан.



Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Авзага трейд билдинг, 505 тоот



<https://www.facebook.com/JICA.START.2>



<https://www.jica.go.jp/project/mongolia/029/index.html>



jicastart2@gmail.com



+976-80486690
+976-95937356

